

2017 оны 12 сарын 23-р өдрийн А/893
.. тоот тушаалын 1 дүгээр хавсралт



МИАТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН МАРКЕТИНГИЙН ХЭЛТЭС

МИАТ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН АГААРЫН ХӨЛГӨӨР ЗАХИАЛГАТ НИСЛЭГ ҮЙЛДЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ

2017 он



АГУУЛГА

1. Тодорхойлолт
2. Захиалгат нислэг үйлдэх журам боловсруулах шаардлага, үзэл баримтлал
3. Нийтлэг үндэслэл
4. Захиалагч талд тавигдах шаардлага
5. Захиалгат нислэгийн хүсэлт гаргах заавар, нөхцөл
6. Захиалагч талын бүрдүүлэх материал
7. Захиалгат нислэгийн хүсэлт хүлээн авах хугацаа
8. Анхаарах зүйл
9. Захиалгат нислэгийн хүсэлтийг шийдвэрлэх
10. Захиалгат нислэгийн хүсэлтийг хүлээн авахаас татгалзах
11. Бусад болон MIAT ХК-ийн хаяг, холбоо барих

ХАВСРАЛТУУД

1. Захиалгат нислэгийн хүсэлт ирүүлэх албан бичгийн ерөнхий загвар
2. Гэрээ дүгнэсэн акт

Edition: 1	Date: 05/12/17	МИАТ Хувьцаат Компани Маркетингийн Хэлтэс
Revision: 1	Date: 05/12/17	



**МИАТ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
АГААРЫН ХӨЛГӨӨР ЗАХИАЛГАТ НИСЛЭГ
ҮЙЛДЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ**

1. Тодорхойлолт

МИАТ ХК гэж “Монголын Иргэний Агаарын Тээвэр” хувьцаат компани.

Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ гэж агаарын хөлгөөр арилжааны нислэгийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгож буй тусгай зөвшөөрөл.

Агаарын тээвэрлэгч гэж агаарын тээврийн гэрчилгээний үндсэн дээр агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага.

Захиалагч тал гэж аялал жуулчлалын байгууллага буюу аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бүрдүүлэх, сурталчилах, худалдах, худалдан авах, аялал жуулчлалын багц буюу тухайлсан үйлчилгээг зохион байгуулж байгаа ашгийн төлөө хуулийн этгээд.

Захиалгат нислэг гэж агаарын тээвэрлэгч, захиалагч байгууллагатай хийсэн тусгай гэрээгээр зохицуулагдаж байгаа хуваарыт бус, нэмэлт бус нислэг.

Захиалгат нислэгийн хүсэлт гэж энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу захиалагч байгууллагаас ирүүлсэн албан бичиг.

Захиалгат нислэгийн үнэ гэдгийг захиалгат нислэгийн хүсэлтийг үндэслэн гаргасан тухайн нислэгийг үйлдэхтэй холбогдон гарах үйл ажиллагааны зардал, холбогдох татвар, хураамжууд болон ашгийн хувь орсон нийт мөнгөн дүн.

Захиалгат нислэгийн хүчинтэй хугацаа гэдгийг энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу байгуулсан гэрээний “Хүчинтэй хугацаа” зүйлд заасан хугацаа гэж ойлгох боловч тухайн гэрээ, түүний үр дагавартай холбоотой аливаа хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Онцгой үүргийн нислэг гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Их хурлын дарга, Ерөнхий сайд, гадаад улсын төрийн өндөр хэмжээний зочдыг тээвэрлэх болон тогтоосон агаарын замаас гадна зайлшгүй шаардлагатай үйлдэх улсын агаарын хөлгийн нислэг.

Тусгай үүргийн нислэг гэж гамшиг, аюулт үзэгдэлтэй тэмцэх, тайван цагийн батлан хамгаалах, хил хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, яаралтай эмнэлэгийн зэрэг түргэн тусламжийн зорилгоор үйлдэж буй нислэг.

Карго гэж ачааны дагалдах хуудас бичигдсэний үндсэн дээр агаарын хөлгөөр тээвэрлэгдэж байгаа эд бараа.



МИАТ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН АГААРЫН ХӨЛГӨӨР ЗАХИАЛГАТ НИСЛЭГ ҮЙЛДЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ

2. Захиалгат нислэг үйлдэх журам боловсруулах шаардлага, үзэл баримтлал

Монгол Улсын аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах, тур операторуудын бүтээгдэхүүн боловсруулах ажлыг хөнгөвчлөх, тодорхой болгох, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх, МИАТ ХК болон Захиалагч талуудын уялдаа холбоог сайжруулах, эх сурвалж тодорхойгүй олон төрлийн мэдээллийн сувгуудыг арилгаж нэгдсэн нэг ойлголттой болгох шаардлагаар энэхүү журмыг боловсруулсан болно.

Уг журмыг мөрдөн ажилласнаар, компанийн захиалгат нислэгийн талаарх мэдээлэлийн санг цэгцтэй болгох, захиалагч тал болон компанийн хэлтэс алба хоорондын уялдаа холбоо, ажил үүрэг тодорхой болох, үйл ажиллагаа сайжрах нөхцөл бүрдэх юм.

Захиалгат нислэгийг үйлдэхэд агаарын тээвэрлэгч болон захиалагч талуудын уялдаа холбоо ихээхэн чухал байдаг. Учир нь захиалгат нислэгийн буулт-хөөрөлт, газрын үйлчилгээ, аэронавигац гэх мэт хураамжууд тогтмол нислэгээс өндөр байдаг боловч давуу эрхийн хувьд тогтмол нислэгийн дараагаар тавигддаг. Тодруулвал аливаа Улсын Иргэний Нисэхийн Удирдах байгууллагаас захиалгат нислэгийг аль болох хуваарын нислэгийн үйл ажиллагаанд нелөөлөхгүй байхаар буюу нисэх буудлын ачаалал их үеэр зөвшөөрөл олгодоггүй, нислэгүүд хуваарын цагаас саатах нөхцөлд захиалгат нислэгүүдийг хамгийн сүүлд хуваарьлах гэх мэт зохицуулалтууд хийдэг тул харьцангуй хязгаарлагдмал орчинтой.

МИАТ ХК-ийн хувьд үйлдсэн захиалгат нислэгийн тоо сүүлийн жилүүдэд огцом өссөн. МИАТ ХК нь өөрөө ашгийн төлөөх бизнесийн байгууллага ба зах зээл жижиг, шаардлага хангахуйц аялал жуулчлалын байгууллага бага, хуваарын нислэгээр гаргаж буй суудлын тоо нь тухайн зах зээлдээ таарсан ба илүүдэл нийлүүлэлт нь санхүүгийн эрсдэлд оруулах магадлалтай зэрэг нөхцөл байдлыг харгалzan энэхүү журмыг боловсруулсан болно.



МИАТ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН АГААРЫН ХӨЛГӨӨР ЗАХИАЛГАТ НИСЛЭГ ҮЙЛДЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ

3. Нийтлэг үндэслэл

МИАТ ХК-иар захиалгат нислэг үйлдэх хүсэлт гаргагч аж ахуйн нэгжүүд, тэдгээрийн гэрээ байгуулах хүртэлх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

МИАТ Хувьцаат Компанийн Маркетингийн хэлтэс нь Захиалгат нислэгийг компанийн хуваарын нислэгийн үйл ажиллагаанд нөлөөлөхгүй байхаар зохион байгуулна.

Захиалгат нислэгийн хүсэлт нь МИАТ Хувьцаат Компанийн үндсэн үйл ажиллагаанд серөг нөлөө үзүүлэх агуулгагүй байна.

Энэхүү журамд Онцгой болон Тусгай үүргийн нислэгүүд хамаарахгүй болно.

4. Захиалагч талд тавигдах шаардлага

Захиалгат нислэг үйлдэхээр хүсэлт гаргагч аж ахуйн нэгж нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж байх.
- Тусгай зөвшөөрөл буюу тур операторын ангилалын гэрчилгээтэй байх.
- Тур операторын ангилалын гэрчилгээгээ ашиглан хамгийн багадаа 1 жилийн хугацаанд тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн байх.
- МИАТ ХК-д санхүүгийн шууд болон шууд бус хэлбэрээр ямар нэг хугацаа хэтэрсэн өргүй байх.
- Аялал зохион байгуулах санхүүгийн болон боловсон хүчиний чадамжтай байх.

5. Захиалгат нислэгийн хүсэлт гаргах заавар, нөхцөл

Захиалгат нислэг зохион байгуулах үндсэн дараалал:

- Захиалагч тал хүсэлтээ МИАТ ХК-ийн төв оффист хаяглан шуудангаар эсвэл биечлэн, хуулбарыг электрон шуудангаар Маркетингийн хэлтсийн дарга болон хариуцсан мэргэжилтэнд тус тус хүргүүлнэ.
- МИАТ Хувьцаат Компанийн Маркетингийн хэлтсийн холбогдох мэргэжилтэн бүрдэл хангасан хүсэлтийг хүлээн авсны дараа 10 хоногт багтаан Захиалгат нислэг үйлдэх боломжтой эсэхэд хариу өгөх ба боломжтой тохиолдолд үнийн санал, тухайн нислэгийн мэдээлэл, цагийн хуваарийг урьдчилсан байдлаар Захиалагч талд хүргүүлнэ.



**МИАТ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
АГААРЫН ХӨЛГӨӨР ЗАХИАЛГАТ НИСЛЭГ
ҮЙЛДЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ**

- МИАТ ХК-ийн үнийн санал ажлын 5 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Захиалагч тал энэхүү хугацаанд үнийн саналыг хүлээн авч гэрээ байгуулах хүсэлтээ МИАТ ХК-д хүргүүлсэн байна.
- МИАТ ХК нь гэрээ байгуулах хүсэлтийг хүлээн авсан даруй захиалгат нислэгийн гэрээний төслийг цахим хаягаар Захиалагч талд хүргүүлнэ.
- Гэрээний хүчинтэй хугацаа дуусмагц тухайн гэрээг дүгнэж акт үйлдэнэ.

Захиалгат нислэг зохион байгуулахад гарах нөхцөлүүд:

- Захиалгат нислэгийн хүсэлтэд 4-өөс дээш чиглэл орсон бол хариу өгөх хугацаа илүү гарсан чиглэл тутамд 1-2 хоногоор хойшлоно.
- Гэрээ байгуулсаны дараагаар нислэгийн зөвшөөрөл авах үйл ажиллагаа эхлэх бөгөөд МИАТ ХК нь тухайн үйл явцыг хянаж, захиалагч талыг мэдээллээр тасралтгүй хангана.

6. Захиалагч талын бүрдүүлэх материал

Үндсэн материал:

- ✓ Захиалгат нислэгийн хүсэлт
- ✓ Тусгай зөвшөөрөл буюу тур операторын ангилалын гэрчилгээ
- ✓ Нислэгийн зорилго нь хурал, спортын тэмцээн гэх мэт бусад арга хэмжээнд оролцох бол тухайн арга хэмжээг зохион байгуулж буй эсвэл оролцож буйг баталсан баримт

Хэрэв МИАТ ХК-д анх удаа эсвэл 2-оос дээш жил завсарласны дараагаар хүсэлт гаргаж байгаа бол дараах материалыг нэмэлтээр бүрдүүлж өгнө. Үүнд:

- ✓ Байгууллагын гэрчилгээ
- ✓ Байгууллагын танилцуулга
 - Сүүлийн 2 жилд эрхэлсэн үйл ажиллагааны товч мэдээлэл
 - Төлбөр төлөх чадвартайг нотолсон баримт /банкны баталгаа, дансны хуулга/
- ✓ Бусад шаардлагатай бичиг баримтууд

7. Захиалгат нислэгийн хүсэлтийг хүлээн авах хугацаа

- a. Захиалгат нислэгийн хүсэлтийг нислэг үйлдэхээс хамгийн багадаа 45 хоногийн өмнө ирүүлсэн байна.
- b. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын харъяа нутаг дэвсгэр дээрх нийтлэг бус цэгруү нислэг үйлдэх нөхцөлд Захиалгат нислэгийн хүсэлтийг нислэг үйлдэхээс хамгийн багадаа 60 хоногийн өмнө ирүүлсэн байна.



**МИАТ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
АГААРЫН ХӨЛГӨӨР ЗАХИАЛГАТ НИСЛЭГ
ҮЙЛДЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ**

8. Захиалгат нислэгийн чиглэл өөрчлөхөд гарах нэмэлт үйлчилгээний хураамж

- Хэрэв Захиалагч тал нь нислэгийн хүсэлт ирүүлээд түүндээ нислэгийн тооцоо гаргуулсан, үнийн санал хүлээн авсаны дараагаар чиглэл солих тохиолдолд хүсэлтийг дахин шинээр гаргах ба МИАТ ХК-д 100 ам.доллартай тэнцэх хэмжээний хураамж төлж өөрчлөлт оруулна. Захиалагч тал нь шинэ хүсэлтээ 6 сараас дээш хугацааны дараа гаргаж байгаа бол дээрх хураамжаас чөлөөлөгднө.
- МИАТ ХК нь Захиалгат нислэг үйлдэхээс хамгийн багадаа 45 хоногийн өмнө нислэгийн чиглэл солих болон өөрчлөлт оруулах хүсэлтийг авч боломжтой тохиолдолд холбогдох өөрчлөлтийг оруулна.

9. Захиалгат нислэгийн хүсэлтийг шийдвэрлэх

МИАТ ХК-иас захиалгат нислэгийн хүсэлтийг ирүүлсэн хугацааг удирдлага болгон дараалалд оруулж хариу өгөх боловч зарим онцгой тохиолдлуудад дараах байдлуудыг үндэслэж шийдвэрлэнэ.

- Адил чиглэлд, адил буюу ойролцоо хуваарийн дагуу нислэг үйлдэхээр байгууллагууд хүсэлт ирүүлсэн нөхцөлд түрүүлж ирсэн хүсэлтийг сонгох боловч зарим тохиолдолд Захиалагч талуудаас ирүүлсэн Хүсэлт, бичиг баримтын иж бурдэл, захиалагчид тавигдах шаардлага зэргийг харгалzan ижил хугацаанд давуу тал, битүүмжилсэн үнийн саналыг дахин авч өндөр үнэ эсвэл илүү үр өгөөжтэй давуу тал санал болгссон талд шийдвэрлэх. Ингэхдээ Монгол Улсын аялал, жуулчлалын салбар, эдийн засаг, гадаад орнуудаас орох мөнгөн урсгалыг дэмжих үүргийнхээ хүрээнд дараах нэмэлт баримтуудыг үндэслэн сонголт хийнэ.
 - Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих,
 - Хэрэв гадаад улсын иргэдийг Монгол Улсад аялуулах зорилготой тохиолдолд тухайн зорчигчдод үйлчлэх зочид буудал, хоол, унаа, үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэлийг нэмэлтээр авч судлаж үзэн дүгнэлт хийсний үндсэн дээр сонголт хийнэ.
- Хэрэв ижил хугацаанд өөр чиглэлд захиалгат нислэг үйлдэхээр хүсэлт ирүүлсэн бол мөн адил түрүүлж ирсэн хүсэлтийг сонгох боловч тухайн нислэгийн эдийн засгийн үр өгөөж, агаарын хөлгийн бололцоо зэргийг харгалzan МИАТ ХК сонголт хийнэ.

10. Захиалгат нислэгийн хүсэлтийг хүлээн авахаас татгалзах

- Энэхүү журмын утга агуулгатай зөрчилдөх,
- Захиалагч талд тавих шаардлага хангагдаагүй,

Edition: 1
Revision: 1

Date: 05/12/17
Date: 05/12/17

**МИАТ Хувьцаат Компани
Маркетингийн Хэлтэс**



**МИАТ ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
АГААРЫН ХӨЛГӨӨР ЗАХИАЛГАТ НИСЛЭГ
ҮЙЛДЭХЭД БАРИМТЛАХ ЖУРАМ**

- c. Бичиг баримтын бүрдэл дутуу,
- d. 2 ба түүнээс дээш аж ахуйн нэгж түншлэл болон хамтарсан хэлбэрээр, гаргасан хүсэлт,
- e. 7 дугаар зүйлд заасан хугацааг зөрчиж гаргасан хүсэлт,
- f. 8 дугаар зүйлд заасан хураамж төлөгдөөгүй тохиодолд,
- g. Зорчигч тээврийн захиалгат нислэгээр карго тээвэрлэхийг санал болгосон,
- h. MIAT ХК нь аль болох агаарын хөлгийн ашиглалтыг сайжруулах тал дээр илүү анхаарч ажиллах боловч аливаа байгууллагатай гэрээ байгуулсан нөхцөлд захиалагч талынхаа эрх ашгийг хөндөхгүй, төлөвлөгөөг нь эвдэхгүй байх үүднээс тухайн нислэгээс өмнө эсвэл хойно ажлын 15 хоног дотор ижил чиглэлд захиалгат нислэг үйлдэхээр ирүүлсэн өөр байгууллагын захиалгат нислэгийн хүсэлтийг хүлээж авхаас татгалзана. Зөвхөн захиалагч талууд хоорондоо зөвшилцж түүнийгээ баталсан нөхцөлд хүлээж авна.

11. Бусад болон MIAT ХК-ийн хаяг, холбоо барих

a. Бусад

- i. Энэхүү журмын үйлчлэх хүрээ Захиалагч тал нь MIAT компаниас гэрээний төсөл хүлээж авсанаар дуусах бөгөөд түүнээс цааших харилцаа буюу нислэгийн зөвшөөрөл, төлбөр тооцоо захиалгат нислэгийн гэрээгээр зохицуулагдана.
- ii. Энэхүү журмаар зохицуулагдаагүй харилцаанд Монгол Улсын Иргэний хууль, Нисэхийн тухай хууль, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох зүйл заалтыг баримтлана.
- iii. Захиалгат нислэг үйлдүүлэхээр хүсэлт гаргагч тал нь энэхүү шаардлагатай бүхэлд нь уншиж танилцсан ба дагаж мөрдөнө гэж ойлгоно.

b. MIAT ХК-ийн хаяг, утасны дугаар

Монголын Иргэний Агаарын Тээврийн "МИАТ" Төрийн Өмчит Хувьцаат компани

МИАТ ХК-ийн төв байр, Хан-уул дүүрэг, 10-р хороо, Буянт-Ухаа 45

Улаанбаатар 17120, Монгол Улс

Маркетингийн хэлтэс

Утас: 11-284100

Факс: 70049919

Веб: www.miat.com

Sita: ULNDDOM

---оо---

Edition: 1
Revision: 1

Date: 05/12/17
Date: 05/12/17

**МИАТ Хувьцаат Компани
Маркетингийн Хэлтэс**

2017 оны 12 сарын 4-өдрийн №/893.
тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар
баталсан МИАТ ТӨХК-ИЙН Агаарын
хөлгөөр захиалгат нислэг үйлдэхэд
баримтлах журмын хавсралт №1



[Байгууллагын албан Бланк]

МИАТ Хувьцаат Компанид

Огноо _____ Дугаар _____

Захиалгат нислэгийн хүсэлт


Par1. [Захиалгат нислэгийн зорилго, нислэгийн чиглэл, үйлдэх огноо, тээвэрлэх зорчигчдын тоо тэдгээрийн тээшиний мэдээлэл]

Par2. [Тусгай нөхцөл]

Par3. [Бүрдүүлэх материалуудыг хавсралтад тусгасан тухай]

[Албан тушаал, Овог, Нэр, Гарын үсэг] – Байгууллагын тамгаар баталгаажуулна.

2017 оны 12 сарын 11 дүгээр хавсралтад
тоот тушаалын 1 дүгээр хавсралтад
баталсан МИАТ ТӨХК-ИЙН Агаарын
хөлгөөр захиалгат нислэг үйлдэхэд
баримтлах журмын хавсралт № 2



.... тоот гэрээг дүгнэсэн акт

Огноо: оны .. дугаар сарын .. өдөр

Нэг талаас “МИАТ” ТӨХК-ийг төлөөлж Маркетингийн хэлтсийн дарга [Овог, нэр] Нөгөө талаас

.... нар оны .. сарын .. өдөр байгуулсан Захиалагч талын ..., МИАТ-ын ... тоот гэрээний биелэлтийг дараах байдлаар дүгнэж байна. Үүнд:

1. Дүгнэж буй гэрээний зүйл, заалтуудын дугаар

2. Гэрээний зүйл заалтын хэрэгжилтийн талаар

3. Гэрээний төлбөр тооцоо, сар бүрийн тайлан. /эсвэл санхүүгийн тооцоо нийлсэн актыг хавсаргах/

4. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 тал хэрхэн биелүүлсэн, гэрээнээс үүдэн гарсан хохирол байгаа эсэх, байгаа бол хэрхэн арилгах

5. Цаашдын хамтын ажиллагааны талаарх санал хүсэлтүүд

/Энэ нь гэрээний биелэлтийг дүгнэх актын ерөнхий загвар бөгөөд тухайн гэрээнээс шалтгаалан бусад зүйлийг нэмэлтээр оруулж болно./

МИАТ-ИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Маркетингийн хэлтсийн
дарга
[Овог, Нэр]

ЗАХИАЛАГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал]
[Овог, Нэр]

[Огноо]

[Огноо]